



“ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА” АЯНЫ ХҮРЭЭНД САЙНЦАГААН СУМЫН УЛСЫН ТЭРГҮҮНИЙ 4 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Дундговь аймгийн ЗДТГ-ын хууль, эрхзүйн хэлтсээс зохион байгуулж байгаа “ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА” аянд тус цэцэрлэгийн хамт олон 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 01 хүртэл нэгдэн идэвхтэй оролцлоо. Аяны хүрээнд албан хаагчдад болон эцэг эх асран хамгаалагч нарт Авлигын эсрэг хуулийг сурталчилах, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шударга ёсны үзлийг төлөвшүүлэх, авлигын эсрэг дуу хоолойгоо нэгтгэх үйл ажиллагааг зохион байгууллаа.

- Авлигатай тэмцэх газраас гаргасан видео, шторк, зурагт хуудсыг цэцэрлэгийн болон 5 бүлгийн цахим хаягт байршуулан авлигын эсрэг нийт 52 мэдээ, мэдээллийг түгээж сурталчилан ажилласан.



- Цэцэрлэгийн эрхлэгч С. Алимаа нь багш, ажилчдад БШУС-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/545 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн

дүрэм”-ээр ажлын байрны сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд нийт 21 багш, ажилтан хамрагдлаа.

- Байгууллагын “Хуулиа дээдэлъе”, “Саяхан Саяхан” самбараар Авлигын эсрэг хууль болон авлигатай тэмцэх газрын нээлттэй утас 110 дугаарыг сурталчилан багш ажилчид болон эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд хүргэлээ. Сурталчилан байршуулсан зурагт хуудас-10



- Багш ажилчид болон эцэг эх, асран хамгаалагч нарт аяны хүрээнд Авлигын эсрэг хуулиас болон авлигатай тэмцэх газрын нээлттэй утас 110-аар боршур бэлтгэн хүргэлээ. Бэлтгэж хүргэсэн боршурын тоо-86





ТАЙЛАН БИЧСЭН: АРГА ЗҮЙЧ Б. ЭНХЖАРГАЛ